



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 227.

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн хорооны 2012 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 273 дугаар тогтоолоор баталсан "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8.12.14-т дор дурдсанаар нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

8.12.14. "Төмөр замын тээврийн тарифыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсны үндсэн дээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн батална."

2."Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал Р.Батсүхэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132007695